



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 84

Номгон

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 а, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1995 онд үйлдвэрлэгдсэн, 2008 онд Монгол улсад орж ирсэн, 2014 онд 28,0 сая төгрөгөөр худалдан авсан 16,3 сая төгрөгийн үлдэх өртөгтэй Ланд круйзер-80 маркийн, NDJ810061627 арлын дугаартай, сувдан цагаан өнгөтэй, В-4164 ангилал, хөдөлгүүрийн багтаамжтай 30-91 БНХ улсын дугаартай суудлын автомашины худалдах доод үнийг 16,4 сая төгрөг, Зоонозын өвчин судлалын төвийн хөрөнгөд бүртгэлтэй 2005 онд үйлдвэрлэгдсэн, 2005 онд Монгол улсад орж ирсэн, 2005 онд 13718,6 мянган төгрөгөөр худалдан авсан үлдэх өртөггүй УАЗ-22069-033 маркийн 56-98 БНА улсын дугаартай суудлын автомашины худалдах доод үнийг 5,0 сая төгрөгөөр тогтоож тус тус дуудлагаар худалдсугай.

2. Автомашины дуудлага худалдааг холбогдох хууль журмын дагуу 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 11 цагт аймгийн Орон нутгийн өмчийн газрын 117 тоот өрөөнд зохион байгуулж, орлогыг Баянхонгор сумын Төрийн сан банкин дахь татварын бус орлогын 100032000914 тоот данс, аймгийн Орон нутгийн өмчийн газрын 100030051006 тоот дансанд тус тус төвлөрүүлсүгэй.

3. Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

0117225

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР